



**НИЙСЛЭЛИЙН
ОРОН СУУЦНЫ ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 540

Улаанбаатар хот

Г.Даваажавыг ажлаас түр чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.3 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоол, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Даваажав нь Японы засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр”-ийн сонгон шалгаруулалтад тэнцэж, 2 жил хүртэл хугацаагаар өндөр хөгжилтэй оронд магистрын сургалтад хамрагдах болсон тул 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь түр чөлөөлсүгэй.

2. Г.Даваажавын ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулж, хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, албан хэргийн холбогдох материал, баримт бичиг, компьютерийн файл, тавилга, эд хогшлыг акт үйлдэн хүлээж авахыг ажил хүлээлцэх комиссын дарга /Б.Азжаргал/-д үүрэг болгосугай.

Ажлын хэсгийн ахлагч

Б.Азжаргал

Орлогч дарга

Гишүүд

М.Туяа

Захиргаа, санхүүгийн
хэлтсийн дарга

А.Түвшинзаяа

Хууль эрх зүйн мэргэжилтэн

Э.Золзаяа

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
хариуцсан мэргэжилтэн

А.Энэрэл

Нярав

3. Г.Даваажавын түр чөлөөтэй байх хугацаанд суралцах хугацааны жилд ногдох шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон зохих хугацаанд даатгалын санд төлж байхыг ахлах нягтлан бодогч /Б.Пүрэвсүрэн/-д зөвшөөрсүгэй.

4. Г.Даваажавтай холбогдох ээлжийн амралтын болон санхүүгийн бусад тооцоог хийж дуусгахыг ахлах нягтлан бодогч /Б.Пүрэвсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г.ГАНЗОРИГ

114050000255